



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/03

Баянхутаг сум

Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтний албан
тушаалын тодорхойлолтыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Засгийн газрын 2019 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5.1 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 07 сарын 16-ны өдрийн "Зөвшөөрөл олгох тухай" 40 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Албан тушаалын тодорхойлолтонд заагдсан чиг, үүргийг хэрэгжүүлэн ажиллахыг Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэнд үүрэг болгосугай.

ДАРГА



Г.БОЛД